



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 сарын 05 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад газарт Төрийн далбаа байнга мандуулах байршлыг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтоож болно."

2/14¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор төрийн далбааг иргэн, хуулийн этгээдэд хүндэтгэлтэйгээр гардуулан өгч болно."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР